



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 07 сарын 04 өдөр

Дугаар А/471

Булган сум

Тайвань Улсад олон улсын тэмцээнд оролцох  
багш, суралцагчдад дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоол, “Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай” IV/26 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2025 оны А/360 дугаар “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг батлах тухай” захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сургуулийн өмнөх боловсролын хүүхдүүдийн оюун ухаан, гоо зүй, сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх “Steam” үйл ажиллагааны хүрээнд “Mongolia Green Mech-2025” улсын уралдаанд 3 дугаар байр эзлэн амжилт гарган Тайвань улсад зохион байгуулагдах олон улсын тэмцээнд Монгол Улсаа төлөөлөн оролцох болсон Булган сумын 7 дугаар цэцэрлэгийн багш, суралцагчдад 5,000,000 (таван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэг үзүүлэхэд зарцуулагдах санхүүжилтийг “STEAM үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний зардлаас гаргахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

